



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2015 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 99

Улаанбаатар хот

### Хуулийн төслийг нэн яаралтай хэлэлцүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16<sup>1</sup> дугаар зүйлийн 16<sup>1.1</sup> дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Ерөнхий сайдын хүсэлтийг үндэслэн хэлэлцэх асуудлын тов, дарааллыг харгалзахгүйгээр Улсын Их Хурлаар нэн яаралтай хэлэлцүүлсүгэй.

2. Энэ захирамжийн 1 дэх заалтад заасан хуулийн төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангахыг Төрийн байгуулалтын байнгын хороо /А.Бакей/-нд даалгасугай.

ДАРГА



З.ЭНХБОЛД

0000000313